



CRC POST NEWS

2025
04



ЭНЭ ДУГААРТ



ХАРИУЦАА ХЭЛБЭГЭЭНИЙ
ХАМГААГАХ
ВЕРСИ

Метро бизнес төв
А-блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14201-0033

ШУУДАНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН
НЭГЖҮҮДЭД ЭЭЛЖИТ
ТӨЛӨВЛӨГӨӨТ
ХЯНАЛТЫН
АЖИЛ ХИЙГДЭНЭ



ХХЗХ-НЫ ДАРГА
Г.ЧИНЗОРИГ "ETS
ЛОЖИСТИК" ХХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ТАНИЛЦЛАА

ӨСВӨР НАСНЫ
ХҮҮХДҮҮДИЙН ОЛОН
УЛСЫН ЗАХИДАЛ
БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ
ШАГНАЛТНУУД
ТОДОРЛОО



ХЯТАД УЛС
ШУУДАНГИЙН
ХҮРГЭЛТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ
САЙЖРУУЛАХ
ЗОРИЛГООР ХИЙМЭЛ
ОЮУН (AI)
АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ

АНУ
ШУУДАНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЖУРМАА
ШИНЭЧИЛЛЭЭ





ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН
НЭГЖҮҮДЭД ЭЭЛЖИТ ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТЫН
АЖИЛ ХИЙГДЭНЭ

Харилцаа холбооны зохицуулах
хорооноос 2025 онд шуудангийн
тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл
ажиллагаанд ээлжит төлөвлөгөөт
хяналтын ажлыг зохион байгуулна.

2025 оны ээлжит хяналтын ажлыг 5-р сараас эхлэх бөгөөд шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт хяналтыг 2 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх болно.

Энэхүү төлөвлөгөөт хяналт нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.8, 30 дугаар зүйлийн 30.2.2 дахь заалтуудад үндэслэн шуудангийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийг жил бүр хамруулдаг.





ХХЗХ-НЫ ДАРГА Г.ЧИНЗОРИГ “ETS ЛОЖИСТИК” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны Дарга Г.Чинзориг АНУ-д албан томилолтоор ажиллах хугацаандаа АНУ-ын бүх хотоос агаар, газар, далай бүх төрлийн тээврээр Монгол Улс руу ачаа илгээмж явуулдаг ETS Ложистик ХХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа.

ETS Ложистик ХХК нь тээвэр зуучлалын тусгай зөвшөөрөлтэйгээр АНУ-д үйл ажиллагаагаа явуулдаг 100% Монгол хөрөнгө оруулалттай компани юм.



Тус компани нь АНУ-ын Лос Анжелес хотын Лонгбич боомтод байрлах өөрийн агуулахдаа Америкийн бүх төрлийн худалдааны вебсайтаас бараа бүтээгдэхүүний захиалгыг хүлээн авч, Монгол Улс руу түргэн шуурхай илгээдэг бөгөөд АНУ-аас Монгол Улс руу шинэ болон хуучин автомашиныг тээвэрлэн захиалагчийн гарт хүлээлгэн өгөх хүртэлх худалдан авалтын болон тээвэрлэлтийн бүх үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын логистик, шуудангийн салбарт шинэ технологи, ухаалаг шийдлийг нэвтрүүлэн, чанар, шуурхай байдлыг баталгаажуулж ажиллаж буй ETS Ложистик ХХК нь олон улсын тээврийн салбар дахь арвин туршлага дээрээ үндэслэн үйлчлүүлэгчдийн ачаа илгээмжийг хамгийн оновчтой маршрутаар тээвэрлэж, тээвэрлэлтийн бүх үйл явцыг сайтар төлөвлөн зохион байгуулдгаараа үйлчлүүлэгчдийнхээ талархлыг хүртээд байгаа юм.

ETS ЛОЖИСТИК КОМПАНИ НЬ:

- **АГААРЫН ТЭЭВЭР:** АНУ-ын бүх хотоос долоо хоног бүрийн баасан гарагт тогтмол агаарын тээврээр Монгол руу 3–5 хоногийн хугацаанд илгээдэг.
- **ХОЛИМОГ ТЭЭВЭР:** Агаар болон газрын тээврийг хослуулсан хэлбэрээр АНУ-аас Солонгосын Инчон хотод байх өөрийн салбараараа дамжуулан Монгол Улс руу автомашинаар тээвэрлэглэн ирдэг.
- **ГАЗРЫН ТЭЭВЭР:** АНУ-аас FCL буюу 20 тн, 40 тн-ын бүтэн чингэлгээр Монгол руу илүү их хэмжээний ачааг тээвэрлэж, аж ахуйн нэгж, албан байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж байна.

ETS Ложистик ХХК нь Монгол Улсын худалдааны болон шуудан, ачаа тээврийн үйлчилгээнд шинэ технологи, ухаалаг логистикийн шийдлийг нэвтрүүлэн, чанар, шуурхай байдал, хэрэглэгчийн сэтгэл



ханамжийг гол зарчим болгон ажиллаж байгааг ХХЗХ-ны дарга Г.Чинзориг онцлон талархаж, цаашид үйл ажиллагаагаа улам өргөжүүлж, шуудан, ачаа тээврийн салбарт бусдыгаа манлайлан энэхүү ололт амжилт, туршлагаа бусадтайгаа хуваалцахыг хүслээ.

ETS Ложистик ХХК нь Монгол Улсад Шипт Рүүт ХХК-тай хамтран, улс хоорондын шуудангийн илгээмжийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчдэд улам ойр, баталгаатай үйлчилгээг үзүүлж байна.



“ӨӨРИЙГӨӨ ДАЛАЙ ГЭЖ ТӨСӨӨЛБӨЛ ЯАГААД ЧАМАЙГ ХАЙРЛАН ХАМГААЛАХ ХЭРЭГТЭЙ ТАЛААР БИЧЭЭРЭЙ” ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ЗАХИДАЛ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ ШАГНАЛТНУУД ТОДОРЛОО



Дэлхийн шуудан холбооноос 54 дэх удаагаа зарласан “Өөрийгөө далай гэж төсөөлбөл яагаад чамайг хайрлан хамгаалах хэрэгтэй талаар бичээрэй” өсвөр насны хүүхдүүдийн олон улсын захидал бичлэгийн уралдааныг Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсын хэмжээнд 9 дэх жилдээ Монгол Шуудан ХК-тай хамтран зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа.



Захидал бичлэгийн уралдаан 2025 оны 1-р сарын 29-нөөс 3-р сарын 15-ны хооронд орон даяар зарлагдаж, төрийн болон хувийн хэвшлийн нийт 700 гаруй ерөнхий боловсролын сургуулийн 2500 орчим хүүхдүүд захидал бичиж ирүүлжээ.

Энэ жилийн захидал бичлэгийн уралдааны сэдэв нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын “Далай, тэнгис, тэдгээрийн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах” 14 дэх зорилтод чиглэж байгаагаараа онцлог байсан бөгөөд сэдвийн хүрээнд хамгийн сайн бичсэн 15 сурагч, уралдааны сэдэв, зорилгыг сурагчдадаа ойлгуулж сургууль, анги хамт олноо идэвхтэй зохион байгуулж оролцсон 5 багшийг тус тус шалгаруулсан.

Хэдийгээр Монгол Улсад далай тэнгис байхгүй ч захидал бичлэгийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн сурагчид дэлхийн гадаргын 71%-ийг эзэлдэг тэнгис далайг бид яагаад хайрлан хамгаалах ёстой талаар өөр өөрсдийн өнцгөөс тун сонирхолтойгоор бичсэн байлаа.



Шуудангийн хаягийг хэрхэн зөв бичих тухай уралдааны зурагт хуудас дээр тодорхой зааж өгсөн бөгөөд шуудангийн хаягаа зөв бичсэн захидлуудаас эхний шатны шалгаруулалтыг хийж 2500 захидлаас шүүгчдийн бүрэлдэхүүн захидлын бүтэц, найруулга, судалгаа, асуудлыг тодорхойлсон байдал, хэрэгжих боломж шийдэл, хиймэл оюун ухаан болон бусад эх сурвалжаас хуулсан эсэхэд шүүлт хийн шилдэг 15-д дараах хүүхдүүдийн захидлыг шалгаруулсан байна. Үүнд:

Тэргүүн байранд:

1. Э.Эмүжин – Булган аймаг Булган сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9в ангийн сурагч



Дэд байранд:

1. Д.Номунгэгээ – Нийслэлийн ХУД-ийн Ерөнхий боловсролын Орхон Хасу сургуулийн 9д ангийн сурагч
2. Ч.Чинхүслэн – Нийслэлийн БЗД-ийн Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургууль 7-р ангийн сурагч



Гуравдугаар байранд:

1. Г.Цэлмүүн - Нийслэлийн СХД, Ерөнхий боловсролын 123-р сургуулийн 10б ангийн сурагч
2. М.Анужин - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 23-р сургуулийн 10а ангийн сурагч
3. М.Оюунхишиг – Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын 15-р сургуулийн 9а ангийн сурагч



Дөрөвдүгээр байранд:

1. И.Нандин-Эрдэнэ. Өмнөговь аймаг, Манлай сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9б ангийн сурагч
2. С.Бүжинлхам - Нийслэлийн БГД-ийн Ерөнхий боловсролын Орхон Хасу сургуулийн 8б ангийн сурагч
3. Д.Эрхсаран – Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 8в ангийн сурагч
4. А.Сэлэнгэ - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 24-р сургуулийн 9г ангийн сурагч



Тавдугаар байранд:

1. Ю.Ариунгоо – Завхан аймаг. Арвайхээр. Ерөнхий боловсролын Чандмань Эрдэнэ сургуулийн 9г

- ангийн сурагч
2. А.Болортунгалаг - Нийслэлийн Налайх дүүргийн Ерөнхий боловсролын Тэрэлж Боардинг сургуулийн 7-р ангийн сурагч
 3. С.Аймөлдир – Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 8в ангийн сурагч
 4. Т.Сайханбаяр – Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9в ангийн сурагч
 5. О.Энхжаргал – Нийслэлийн Ерөнхий боловсролын 116-р сургуулийн 8б ангийн сурагчид тус тус шалгарлаа.

оролцогчдын тооноос хамааруулж дараах 5 багшийг шалгаруулсан. Үүнд:

1-р байр: **С.Нансалмаа** - Өмнөговь аймгийн Манлай сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн багш /2-р шатны шалгаруултад 133 сурагчийн захидал тэнцэж, шилдэг 15-д 1 сурагч шалгарсан/

2-р байр: **Д.Даваасүрэн** - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 24-р сургуулийн багш /2-р шатны шалгаруултад 83 сурагчийн захидал тэнцэж, шилдэг 15-д 1 сурагч шалгарсан/



Шилдэг 5 багшийг захидал бичлэгийн уралдаанд хүүхдүүдийг идэвхтэй оролцуулсан байдал, уралдааны сэдэв, зорилгыг сурагчдадаа ойлгуулсан байдал, захидлын агуулга, найруулга, хаягжилтад зөвлөгөө өгсөн байдлыг үнэлэн эхний 2 шатны шалгаруулалтанд тэнцсэн

3-р байр: **Б.Уранбилэг** - Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн багш /2-р шатны шалгаруултад 70 сурагчийн захидал тэнцэж, шилдэг 15-д 1 сурагч шалгарсан/

4-р байр: **Б.Байгалмаа** - Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын



15-р сургуулийн багш /2-р шатны шалгаруултад 63 сурагчийн захидал тэнцэж, шилдэг 15-д 1 сурагч шалгарсан/

5-р байр: Ц.Баярцэцэг - Нийслэлийн Налайх дүүргийн Ерөнхий боловсролын Тэрэлж Боардинг сургуулийн багш /2-р шатны шалгаруултад 56 сурагчийн захидал тэнцэж, шилдэг 15-д 1 сурагч шалгарсан/



Энэ жилийн захидал бичлэгийн уралдааны онцлогууд юу байв?

1-рт: Захидал бичлэгийн уралдаанд анх удаагаа 21 аймгаас оролцлоо. Баян-Өлгий аймгаас энэ удаагийн уралдаанд 8 захидал ирснээс Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 8в ангийн сурагч С.Аймолдирын захидал шилдэг 15-т багтлаа.



2-рт: Үндэсний хэл бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгын хүрээнд 2-р шатанд шалгарсан захидлуудын 30% нь монгол бичгээр бичигдсэн.

3-рт: Энэ удаагийн захидал бичлэгийн уралдаанд анх удаагаа тусгай хэрэгцээт хүүхдүүд брайль бичгээр өгсөн агуулгын хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын 116-р сургуулийн 86 ангийн сурагч О.Энхжаргалын захидал шилдэг 15-д багтсан юм.



Ийнхүү жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичлэгийн уралдаан амжилттай явагдаж шалгарсан багш, сурагчид шагналаа гардан авлаа.

Тэргүүн байр эзэлсэн үндэсний ялагч Булган аймгийн Булган сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 9в ангийн сурагч Э.Эмүжингийн бичсэн захидлыг Англи, Франц хэл рүү хөрвүүлэн Дэлхийн шуудан холбооны олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичлэгийн уралдаанд Монгол Улсыг төлөөлөл илгээлээ.

ШУУДАНГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛАХ ХҮСЭЛТЭЭ ЦАХИМААР ӨГНӨ ҮҮ

2025 оны эхний хагас жилд тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусч байгаа дараах аж ахуйн нэгжүүд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 2-т заасны дагуу зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргана гэж заасны дагуу цахимаар илгээнэ үү.

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА НЬ ДУУСЧ
БАЙГАА ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГУУД

Д/д	Зөвшөөрлийн №	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэрс	Дуусах хугацаа	Үйлчилгээний хамрах хүрээ
1	43200017	Англофрейт ХХК	2025-05-23	Монгол Улс - АНУ
2	43200124	Бинчин хүү ХХК	2025-05-14	Монгол Улс - БНСУ
3	43200125	Эйр пасифик ХХК	2025-05-14	Монгол Улс - ХБНГУ
4	43200169	Гран тэмүн ХХК	2025-03-30	Монгол Улс-АНУ
5	43200171	Эл Би Карго ХХК	2025-04-28	Монгол Улс-БНТУ
6	43200173	Шипт рүүт ХХК	2025-04-28	Монгол Улс-АНУ
7	43200175	Орчс ХХК	2025-04-28	Монгол Улс-АНУ
8	43200176	Эм Эф Юу ХХК	2025-04-28	Монгол Улс-БНЧУ
9	43200177	Коожицу монголиа ххк	2025-05-26	Монгол Улс-Япон Улс
10	43400015	Мишээл карго ХХК	2025-05-14	Дотоод
11	43400063	Амар экспресс ХХК	2025-04-28	Дотоод
12	43400064	Ашид шуудан ХХК	2025-04-28	Дотоод
13	43400065	Ти Юу Хүргэлт ХХК	2025-04-28	Дотоод
14	43400066	Соёл экспресс пост ХХК	2025-05-26	Дотоод

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛАХ
ХҮСЭЛТ ЦАХИМААР ИЛГЭЭХ ЗААВАР

[illegible]

ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Боловсролын үнэмлэхийг
 Үндэсний боловсролын үнэмлэхийн
 системд тусгах үйлдлийг
 "Тустай зөвшөөрөл"

- 1. Тусгай зөвшөөрөл олгох үйлдлийг
 системд оруулах үйлдлийг хийх
- 2. Тусгай зөвшөөрөл олгох үйлдлийг
 системд оруулах үйлдлийг хийх
- 3. Тусгай зөвшөөрөл олгох үйлдлийг
 системд оруулах үйлдлийг хийх

Year	Population (millions)	Population growth rate (%)	Population density (per sq km)	Population density (per sq mile)	Population density (per sq km)	Population density (per sq mile)	Population density (per sq km)	Population density (per sq mile)
1950	2.5	1.5	150	390	150	390	150	390
1960	3.0	2.0	180	460	180	460	180	460
1970	3.5	2.5	210	540	210	540	210	540
1980	4.0	3.0	240	620	240	620	240	620
1990	4.5	3.5	270	700	270	700	270	700
2000	5.0	4.0	300	780	300	780	300	780
2010	5.5	4.5	330	860	330	860	330	860
2020	6.0	5.0	360	940	360	940	360	940

[illegible][illegible][illegible][illegible]

СИСТЕМД НЭВТРЭХ, ДҮР СОНГОХ

Түстай зөвшөөрөл
МОНГО

Хэрэглэгчид өөрсдийн өмчийг хамгаалах зорилгоор...

**ТҮСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
СҮНГАЛТЫН ХҮСЭЛТ ИЛГЭЭХ**

ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТ

[illegible][illegible]



СУРГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

ШУТИС- МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГАЛТЫН ТӨВТЭЙ ХАМТАРСАН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА

Харилцаа холбооны зохицуулах хороо, ШУТИС-Мэдээлэл, холбооны технологийн сургалтын төвтэй хамтарсан Мэдээлэл, холбооны технологийн салбарын шуудан холбооны мэргэжилтнүүдийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулагдаж байна.

Уг сургалт нь шуудангийн салбарын ажилтнуудад харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн салбарын мэдлэгийг мэргэжлийн сургалтын байгууллагаас олгох, мэргэшүүлэх зорилготойгоор жил бүр зохион байгуулагддаг билээ.

ШУТИС-тай хамтран зохион байгуулж байгаа энэхүү сургалтанд шинээр тусгай зөвшөөрөл авсан болон шуудангийн үйл

ажиллагаагаа эрхэлж байгаа 18 аж ахуйн нэгжийн 20 орчим ажилтан хамрагдаж байна.

Энэхүү сургалтанд хамрагдсан шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн ажилтнуудад “Мэдээлэл холбооны технологийн салбарын шуудан холбооны мэргэжилтнүүдийн мэргэжил дээшлүүлсэн” гэрчилгээ олгогдох бөгөөд 2 жил тутам сургалтанд дахин хамрагдах шаардлагатай юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг Шуудангийн зохицуулалтын мэргэжилтэн У.Есөнтөмөр /95701126, yesuntumur@crc.gov.mn/-тэй холбогдож авна уу.




ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД ЦАХИМ СУРГАЛТЫН СИСТЕМИЙГ АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ

Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хилийн чанад дахь хамтрагч байгууллагуудын ажилтнуудыг цагийн зөрүүгүйгээр сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэх зорилгоор Цахим сургалтын платформыг нэвтрүүлж, шуудангийн үйлчилгээ эрхлэгч нэвтрэх эрх бүхий <https://crc.gosmart.mn/#/login> холбоосыг үүсгэж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, технологи ажиллагааны цуврал 4 төрөл 10 видео хичээлүүдийг бэлтгэн орууллаа.

Энэхүү программд байгууллага бүрт үндсэн хаяг нээгдсэн бөгөөд ажилтан өөрөө нэмж хаяг бүртгүүлэх боломжтой.

Уг цахим холбоосоор орж, бүртгүүлснээр та бүхэн Харилцаа холбооны зохицуулах хороо, ЦЕГ-Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар гэх мэт хамтарсан сургалт тогтмол зохион байгуулдаг байгууллагуудын танилцуулга, сургалтын материал, заавар зөвлөгөө, мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болох юм.

Иймд та бүхэн уг цахим сургалтын системд хандан сургалт, мэдээллийг авч үйл ажиллагаандаа ашиглана уу.





ХЯТАД УЛС ШУУДАНГИЙН ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ХИЙМЭЛ ОЮУН (AI)



ГАДААД МЭДЭЭ

АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ

Хятадын шуудангийн байгууллагын шуудангийн илгээмж, логистик, тээвэрлэлт хариуцсан нэгж цахим шилжилтийг хурдасгах зорилгоор DeepSeek-R1 дэвшилтэт хиймэл оюуны загварыг албан ёсоор нэвтрүүлснээ зарлалаа.

Хиймэл оюун ухааныг ийнхүү үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь тус байгууллагын гурван жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд томоохон алхам болж байна.

2020 оноос хойш Хятадын шуудангийн байгууллагын шуудангийн илгээмж, логистик, тээвэрлэлт хариуцсан нэгж нь дуунд суурилсан байршил чиглүүлэгч, текстэд суурилсан техникийн дэмжлэг, цахим туслах зэрэг ухаалаг хэрэгслүүдийг нэвтрүүлж эхэлсэн. Мөн харилцагчийн төвийн 11,183 ширхэг үйлчүүлэгчтэй харилцах дугаарыг үр ашиг, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үүднээс AI-д суурилсан технологийг нэвтрүүлж, шинэчилээд байгаа юм.

Тус нэгж нь шуудангийн болон тээвэрлэлтийн орчинд ашиглах төрөл бүрийн хиймэл оюуныг туршиж байна.

Хятад улсад 2025 оны хаврын баярын үеэр хүчирхэг гүйцэтгэлтэй, гар утас, таблет зэрэг ухаалаг төхөөрөмжид нөөц ашиглалт, эзлэх зай хэмжээ бага гэдгээрээ алдаршаад байгаа DeepSeekR1-ийг танилцуулсан нь Хятад шуудангийн байгууллагад хамгийн тохиромжтой хувилбарт тооцогдоод байна.

Тиймээс Хятад шуудангийн байгууллага нь тус загварыг өөрийн үйл ажиллагаандаа богино хугацаанд нэвтрүүлж, тухайн хувилбарт зориулж дотоод өөрчлөлтийг гүйцэтгэж эхлээд байгаа юм.

Тус хиймэл оюуны загвар нь үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд хиймэл оюунд суурилсан цахим туслах программуудыг гүйцэтгэлээр хангах болно. Зарим бүс нутагт үр ашгийн өсөлт нь 33% -иас давах төлөвтэй байна.

ХОНКОНГ ШУУДАН FedEx-ийн ИЛГЭЭМЖ ХҮЛЭЭН АВАХ УХААЛАГ СҮЛЖЭЭГ ДЭМЖИН АЖИЛЛАНА



ГАДААД МЭДЭЭ



Хонконг шуудан (Hong Kong Post) FedEx-тэй хамтран Хонконгийн үйлчлүүлэгчдэд илгээмжээ өөрсдөө хүлээн авах сүлжээг өргөжүүлж үйлчилгээгээ улам ойртуулж байна.

FedEx-ийн үйлчлүүлэгчид 2025 оны 4-р сарын 1-нээс эхлэн Хонконг шуудангийн 119 салбар, 165 iPostal шуудангийн хайрцаг зэрэг 700 гаруй цэгээс өөрийн илгээмжийг хүссэн үедээ шууд хүлээн авах боломжтой болжээ.

Өөрөөр хэлбэл хэрэглэгч FedEx Delivery Manager эсвэл WhatsApp-аар дамжуулан өөрийн ачаа илгээмжээ хүлээн авах цэгийг оршин суугаа газар, өөрт ойрхон салбаруудаас үнэ төлбөргүйгээр сонгох болсон нь цахим худалдааны худалдан авагчдад илүү тав тухтай, уян хатан байдлыг санал болгож байгаа юм.

Энэхүү хүргэлтийн ухаалаг үйлчилгээг нэвтрүүлснээр Хонконг шуудангаас ачаа илгээмж хүлээн авагчид илгээмжийг гардуулах үйл ажиллагааны хүртээмжтэй, найдвартай байдал нэмэгдэж, хил дамнасан цахим худалдааг дэмжиж байна.





ГАДААД МЭДЭЭ

АНУ ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРМАА ШИНЭЧИЛЛЭЭ

АНУ-ын шуудан (USPS) 4-р сарын 1-нээс үйл ажиллагаандаа үйлчилгээний шинэ журмыг хэрэгжүүлж эхэлснээр баталгаат шуудан болон ялган боловсруулах төвөөс 80 км-ээс илүү зайд тээвэрлэх агаарын шуудангийн хүргэлтийн үйлчилгээнд өөрчлөлт орж байна.

Хөдөө орон нутаг дахь тээврийн маршрут нэг өдөрт хоёр удаагийн хүргэлтийн давтамжтай байсныг шинэчилсэн журмаар нэг болгон багасгасан нь хүргэлтийн дундаж хугацаа нэг өдрөөр дахин нэмэгдэж, удаашрах хандлагатай болоод байна.

Шинэчлэгдсэн үйлчилгээний журмаар ялган боловсруулах төвтэй ойрхон хот суурин газарт илгээмж хурдан хүргэгдэх бол хөдөө, орон нутагт харин эсрэгээр, хүргэлтийн хугацаа ихэсжээ.

Хэдий журмын дагуу хүргэлтийн зарим хуваарь өөрчлөгдсөн ч илгээмж хүргэлт батлагдсан хугацаандаа хүргэгдэж байгаа гэж АНУ-ын шуудангийнхан тайлбарлаж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, газрын илгээмж 2-5 хоногт, агаарын илгээмж 1-5 хоног дотор багтаж хүргэгдэж байгаа гэж тэд мэдэгдлээ.





ТАЙЛАНД ШУУДАН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ POSTMAN CLOUD ПЛАТФОРМЫГ АШИГЛАН ӨРГӨЖҮҮЛНЭ.

Тайланд шуудан нь төрийн болон бизнесийн түншүүдэд хүргэлтийг гүйцэтгэдэг 25,000 шууданчийн цуглуулсан өгөгдөл, мэдээллийг хадгалдаг Postman Cloud үйлчилгээний платформуор дамжуулан цахим стратегия хөгжүүлж байна.

Тайланд шуудангийн гүйцэтгэх захирал доктор Данант Субхадрабандугийн хэлснээр уг платформ нь байршил, барилгын судалгаа, бодит цагийн үнэлгээ, бичиг баримт цуглуулах, цахим үнэмлэх баталгаажуулах зэрэг үйлчилгээг үзүүлдэг.

Мөн нэг хүргэлтийн цэгээс нөгөө цэг хүртэл өдрийн дотор болон дараагийн өдөр хүргэх өндөр үнэтэй барааг найдвартай хүргэх үйлчилгээг санал болгодог.

Уг платформын онцлог нь түншийн бүтээгдэхүүнийг тохирсон хэрэглэгчдэд хүргэхэд туслахын тулд тус нутагт хүргэлт хийдэг шууданчдын орон нутгийн талаарх цуглуулсан гүнзгий мэдлэгийг ашиглах боломжтой. Жишээ дурдахад Тайланд шуудан Бангкок Теллинг компанийн улсын хэмжээнд байршуулсан 10,000 гаруй True TYC машины байршлыг олж, буулгах ажилд дэмжлэг үзүүлж байжээ.

Энэхүү үйлчилгээ нь түншүүдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхээс гадна шуудангийн байгууллагад орлогын шинэ боломжийг нээж өгдөг.

Тайланд шуудан мөн өөрийн Прай брэндийг өргөжүүлж, эрч хүчний ундаа, савласан ус, будаа зэрэг бүтээгдэхүүнүүд дээрээ кофег нэмсэн байна.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 ОНЫ 4-Р САР

№	Аж ахуйн нэгжийн нэр	Эрхлэх үйлчилгээ , хамрах хүрээ	ТЗ дугаар
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОГДСОН АЖ АХУЙН НЭГЖ			
1	Баба коммерс	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс - БНХАУ/	43200228



Харилцаа холбооны зохицуулах хороо
Метро бизнес төв А-блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14201-0033

ШУУДАНГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР